



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2024/186/НА-СА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Булган аймаг

2024 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: [erdeneb@audit.gov.mn](mailto:erdeneb@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

ЦЭСБ аудит ХХК-ийн захирал: Ч.Цэрэннадмид  
Утас: 9511-2689 Цахим хаяг: [tsesb.audit@gmail.com](mailto:tsesb.audit@gmail.com)

Ахлах аудитор Ш.Ганчимэг  
Утас: 99377360 Цахим хаяг: [shagdarganchimeg44@jmail.com](mailto:shagdarganchimeg44@jmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12-15
4. Аудитын тайлан.....	17
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16-17
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	17-18
7. Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл.....	19
8. Төлбөрийн акт, 01/147, 02/148.....	20-21
9. Албан шаардлага, 02/114.....	22

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББ	Нягтлан бодох бүртгэл
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



## БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс:7034-2580  
E-mail:bulgan@audit.gov.mn

2024.02.23 № 254

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БАЯН-АГТ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Г.ПҮРЭВСҮРЭН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Агт сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Агт сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам"-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 96,797.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### Аудитын гол асуудал

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 34,454.8 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээс 34,198.0 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж, тодруулсан байна.

006020561

### **Бусад асуудлын хэсэг**

БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалын дагуу ЕБС-ийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлж, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгож эхэлсэн бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшууллын асуудал давхар шийдвэрлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.ЭРДЭНЭ



**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****/төгрөгөөр/**

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>94,192,858.53</b>	<b>220,183,010.00</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>1,080,073.46</b>	<b>96,797,054.37</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>1,080,073.46</b>	<b>96,797,054.37</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>1,080,073.46</b>	<b>96,797,054.37</b>
31211	Төрийн сангийн харилцах	1,080,073.46	96,797,054.37
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,162,287.29</b>	<b>5,123,907.19</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,762,287.29	5,123,907.19
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>400,000.00</b>	<b>0.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	400,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>89,950,497.78</b>	<b>122,423,811.44</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>315,644.00</b>	<b>2,541,451.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	140,644.00	2,491,451.00
35130	Эм боох материал	175,000.00	50,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>89,634,853.78</b>	<b>115,720,597.44</b>
35410	Бичиг хэргийн материал	5,397,000.00	2,728,550.00
35420	Аж ахуйн материал	79,604,014.98	83,510,922.64
35460	Хүнсний материал	1,800,464.80	22,203,318.80
35470	Бусад хангамжийн материал	2,833,374.00	11,439,659.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,584,820,311.26</b>	<b>1,602,831,857.17</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,584,820,311.26</b>	<b>1,602,831,857.17</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,544,615,311.26</b>	<b>1,562,964,357.17</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,528,011,910.00	1,543,011,910.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-186,055,150.73	-231,620,390.73
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	177,699,220.00	260,463,780.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-78,484,199.13	-107,783,799.18
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	142,171,936.11	154,109,936.11
39208	Хуримтлагдсан элэгдэл	-64,157,294.96	-81,595,969.00
39217	Ном	25,428,889.97	26,378,889.97
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>40,205,000.00</b>	<b>39,867,500.00</b>
39301	Програм хангамж	1,750,000.00	1,750,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,075,000.00	-1,412,500.00

39303	Бусад биет бус хөрөнгө	39,530,000.00	39,530,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,679,013,169.79</b>	<b>1,827,176,630.17</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,574,769.79</b>	<b>758,311.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>14,574,769.79</b>	<b>758,311.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>14,574,769.79</b>	<b>758,311.00</b>
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	758,311.00
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>14,574,769.79</b>	<b>0.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	14,574,769.79	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,664,438,400.00</b>	<b>1,826,418,319.17</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,664,438,400.00</b>	<b>1,826,418,319.17</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	796,350,796.72	796,350,796.72
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	796,350,796.72	796,350,796.72
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-271,347,045.56</b>	<b>-109,367,126.39</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-1,922,785,445.56	-271,347,045.56
51220	Тайлант үеийн үр дүн	1,651,438,400.00	161,979,919.17
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,139,434,648.84	1,139,434,648.84
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,679,013,169.79</b>	<b>1,827,176,630.17</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,186,357,556.90</b>	<b>1,957,997,760.27</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,725,881,956.90</b>	<b>83,445,767.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>1,725,881,956.90</b>	<b>83,445,767.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,097,610.00</b>	<b>4,790,400.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,512,610.00	2,790,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,585,000.00	2,000,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0.00	5,141,207.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,618,334,886.12	76,304,560.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	101,449,460.78	2,350,807.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,460,475,600.00</b>	<b>1,874,551,993.27</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,119,966,400.00</b>	<b>1,566,377,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,119,966,400.00	1,566,377,900.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>340,509,200.00</b>	<b>308,174,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,509,200.00	336,070,000.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,531,489,346.25</b>	<b>1,828,075,600.83</b>

<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,531,489,346.25</b>	<b>1,828,075,600.83</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,476,572,353.25</b>	<b>1,748,348,258.10</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>849,705,088.54</b>	<b>1,065,119,156.20</b>
210101	Үндсэн цалин	631,050,065.54	746,140,355.96
210102	Нэмэгдэл	178,420,850.00	251,035,174.87
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	40,234,173.00	67,943,625.37
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>106,616,251.00</b>	<b>132,515,624.65</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,529,485.00	91,462,646.02
210202	Тэтгэмжийн даатгал	8,532,804.00	10,739,351.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,826,303.00	8,517,989.58
210204	Ажилгүйдлийн даатгал	1,738,542.00	1,984,480.05
210205	Эрүүл мэндийн даатгал	16,989,117.00	19,811,157.29
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>290,758,412.50</b>	<b>283,056,080.77</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,275,000.00	8,554,612.72
210302	Түлш, халаалт	284,293,412.50	274,501,468.05
210303	Цэвэр, бохир ус	190,000.00	0.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>0.00</b>	<b>19,315,862.34</b>
210408	Бараа материал акталсны зардал	0.00	19,315,862.34
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>85,501,725.00</b>	<b>106,651,209.00</b>
210502	Хоол, хүнс	85,501,725.00	104,241,070.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>6,913,320.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	6,913,320.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>7,618,200.00</b>	<b>8,639,201.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,035,000.00	2,772,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,583,200.00	5,867,101.05
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>135,372,676.21</b>	<b>126,137,894.09</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,585,012.00	24,318,980.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,318,400.00	9,177,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	81,469,264.21	92,641,014.09
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>54,916,993.00</b>	<b>50,079,632.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>48,804,000.00</b>	<b>50,079,632.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	48,804,000.00	50,079,632.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,112,993.00</b>	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,112,993.00	
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>1,654,868,210.65</b>	<b>157,818,066.17</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,429,810.65</b>	<b>161,979,919.17</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	3,429,810.65	0.00
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>1,651,438,400.00</b>	<b>161,979,919.17</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,465,288,900.00</b>	<b>1,879,342,393.27</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>4,813,300.00</b>	<b>4,790,400.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>4,813,300.00</b>	<b>4,790,400.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>4,813,300.00</b>	<b>4,790,400.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,060,000.00	2,790,400.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,753,300.00	2,000,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,460,475,600.00</b>	<b>1,874,551,993.27</b>
1310	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>1,119,966,400.00</b>	<b>1,566,377,900.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,119,966,400.00	1,566,377,900.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>340,509,200.00</b>	<b>308,174,093.27</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	340,509,200.00	308,174,093.27
II	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,425,824,326.54</b>	<b>1,777,173,319.09</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,425,824,326.54</b>	<b>1,777,173,319.09</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,361,527,133.54</b>	<b>1,686,421,812.36</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>850,105,088.54</b>	<b>1,069,811,421.67</b>
210101	Үндсэн цалин	631,450,065.54	747,484,960.43
210102	Нэмэгдэл	178,420,850.00	251,035,174.87
210104	Урамшуулал	40,234,173.00	71,291,286.37
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>106,616,251.00</b>	<b>132,547,266.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	72,529,485.00	91,462,646.02
210202	Тэтгэмжийн даатгал	8,532,804.00	10,724,470.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,826,303.00	8,501,228.68
210204	Ажилгүйдлийн даатгал	1,738,542.00	1,984,480.05
210205	Эрүүл мэндийн даатгал	16,989,117.00	19,874,440.73
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>280,268,800.00</b>	<b>298,104,093.27</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,930,000.00	8,423,774.13
210302	Түлш, халаалт	274,148,800.00	289,480,319.14
210303	Цэвэр, бохир ус	190,000.00	200,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>78,382,400.00</b>	<b>120,763,800.00</b>
210502	Хоол, хүнс	78,382,400.00	120,763,800.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,000,000.00</b>	<b>10,070,000.00</b>
210604	Урсгал засвар	1,000,000.00	10,070,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>9,863,600.00</b>	<b>11,079,201.05</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,035,000.00	2,772,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7,828,600.00	8,307,101.05
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>35,290,994.00</b>	<b>44,046,030.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23,548,494.00	31,589,880.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,742,500.00	12,456,150.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>64,297,193.00</b>	<b>62,855,600.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>58,184,200.00</b>	<b>62,855,600.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	58,184,200.00	62,855,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>6,112,993.00</b>	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,112,993.00	
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>39,464,573.46</b>	<b>130,064,980.91</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>38,384,500.00</b>	<b>34,348,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>38,384,500.00</b>	<b>34,348,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>38,384,500.00</b>	<b>34,348,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,384,500.00	34,348,000.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-38,384,500.00</b>	<b>-34,348,000.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>1,080,073.46</b>	<b>95,716,980.91</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,080,073.46
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,080,073.46	96,797,054.37

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	796,350,796.72	1,139,434,648.84	-1,922,785,445.56	13,000,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	-1,922,785,445.56	13,000,000.00
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,651,438,400.00	1,651,438,400.00
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	-271,347,045.56	1,664,438,400.00
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	-271,347,045.56	1,664,438,400.00
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	796,350,796.72	1,139,434,648.84	-271,347,045.56	1,664,438,400.00

14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	161,979,919.17	161,979,919.17
20	<b>2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл</b>	<b>796,350,796.72</b>	<b>1,139,434,648.84</b>	<b>-109,367,126.39</b>	<b>1,826,418,319.17</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,572,521,900.00</b>	<b>1,475,451,319.09</b>	<b>97,070,580.91</b>	<b>93.83</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,572,521,900.00</b>	<b>1,475,451,319.09</b>	<b>97,070,580.91</b>	<b>93.83</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,509,666,300.00</b>	<b>1,412,595,719.09</b>	<b>97,070,580.91</b>	<b>93.57</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,154,762,500.00</b>	<b>1,069,811,421.67</b>	<b>84,951,078.33</b>	<b>92.64</b>
210101	Үндсэн цалин	790,512,000.00	747,484,960.43	43,027,039.57	94.56
210102	Нэмэгдэл	316,048,100.00	251,035,174.87	65,012,925.13	79.43
210104	Урамшуулал	48,202,400.00	71,291,286.37	-23,088,886.37	147.90
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>144,345,300.00</b>	<b>132,547,266.37</b>	<b>11,798,033.63</b>	<b>91.83</b>
210201	Тэтгэврийн даатгал	98,154,900.00	91,462,646.02	6,692,253.98	93.18
210202	Тэтгэмжийн даатгал	11,547,700.00	10,724,470.89	823,229.11	92.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,238,000.00	8,501,228.68	736,771.32	92.02
210204	Ажилгүйдлийн даатгал	2,309,500.00	1,984,480.05	325,019.95	85.93
210205	Эрүүл мэндийн даатгал	23,095,200.00	19,874,440.73	3,220,759.27	86.05
2105	<b>Нормативт зардал</b>	<b>120,763,800.00</b>	<b>120,763,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
210502	Хоол, хүнс	120,763,800.00	120,763,800.00	0.00	100.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур аамж</b>	<b>11,379,200.00</b>	<b>11,079,201.05</b>	<b>299,998.95</b>	<b>97.36</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,063,800.00	2,772,100.00	291,700.00	90.48
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,315,400.00	8,307,101.05	8,298.95	99.90
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>78,415,500.00</b>	<b>78,394,030.00</b>	<b>21,470.00</b>	<b>99.97</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,942,400.00	65,937,880.00	4,520.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,473,100.00	12,456,150.00	16,950.00	99.86
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>62,855,600.00</b>	<b>62,855,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>62,855,600.00</b>	<b>62,855,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,855,600.00	62,855,600.00	0.00	100.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,572,521,900.00</b>	<b>1,571,168,300.00</b>	<b>1,353,600.00</b>	<b>99.91</b>
31	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,566,377,900.00</b>	<b>1,566,377,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,566,377,900.00	1,566,377,900.00	0.00	100.00

35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,144,000.00	4,790,400.00	1,353,600.00	77.97
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,063,800.00	2,790,400.00	273,400.00	91.08
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	1,080,200.00	0.00	1,080,200.00	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,080,073.46	-1,080,073.46	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	96,797,054.37	-96,797,054.37	

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

#### *Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Баян-Агт сумын Ерөнхий боловсролын сургууль нь бүрэн дунд боловсролын үйл ажиллагаа явуулдаг, Боловсрол, шинжлэх ухааны яамны харьяа байгууллага юм.

Тайлант онд “Сурагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж ээлжит хичээлийн чанар үр өгөөжийг нэмэгдүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих, сургуулийн өнөөгийн хүрсэн түвшинг хадгалж, ахиулахад оршино.” гэсэн зорилт дэвшүүлж ажиллажээ.

2022-2023 оны хичээлийн жилд нийт 21 бүлэг, 546 суралцагчид, 35 багш, 32 ажилтны орон тоотой, жилийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөөг БШУЯ, аймгийн БШУГ-ын хичээлийн жилийн зорилго зорилтууд, сургуулийн зорилго зорилтуудтай уялдуулан 8 зорилт 71 арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус сургууль нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, НББ-ийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгал, Татварын багц хуулиуд, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2022 оны 107,192-р тогтоол, БШУС-ын 2022 оны А/500, А/494, А/430, А/122 дугаар тушаал, Засгийн газрын 2023 оны "Төрийн албаны зарим албан тушаалын хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 241 дүгээр тогтоол, "Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагуудын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай" 213 дугаар тогтоол, "Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн тогтоох тухай" 240 дугаар тогтоол, БШУС-ын 2023.06.13-ны өдрийн "Чиглэл хүргүүлэх тухай" 1а/2714 албан бичгээр ЕБС, цэцэрлэгийн нөхөн хангалтыг шийдвэрлэх талаар ирүүлсэн чиглэл зэрэг тайлант онд дээд шатны эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн заавар, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Төсвийн шууд захирагч батлагдсан төсөвт үндэслэн зарлагыг хянан баталж дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол аймгийн Төрийн сан холбогдох санхүүгийн баримт материал, гэрээ, гүйцэтгэлийн баримт бичгийг хянаж, зарлагын гүйлгээг цахимаар хийж байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлон, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн А/424 захирамжаар баталсан Булган аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна. Энэ нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баян-Агт сумын ЕБС-ийн 2023 оны санхүүгийн тайланг УСНББОУС, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тус сургуулийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 148,163.4 мянган төгрөгөөр буюу 8.82 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгийн дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1: Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	1,080.1	96,797.1	95,717.0
Авлага	3,162.3	5,123.9	1,961.6
Байгууллагаас авах авлага			
Бараа материал	89,950.5	122,423.8	32,473.3
Үндсэн хөрөнгө	1,914,592.0	2,025,244.5	110,652.5
Үндсэн хөрөнгийн элэгдэл	(329,771.6)	(422,412.7)	(92,641.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b><u>1,679,013.2</u></b>	<b><u>1,827,176.6</u></b>	<b><u>148,163.4</u></b>
Өр төлбөр		-	
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,664,438.4	1,826,418.3	161,979.9
Өр төлбөр /богино хугацаат/	14,574.8	758.3	(13,816.5)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b><u>1,679,013.2</u></b>	<b><u>1,827,176.6</u></b>	<b><u>148,163.4</u></b>

Тайлант онд Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх журам”-ын 8.7 дахь заалтад төсвийн жилийн эцэст зарцуулагдаагүй үлдсэн мөнгөн хөрөнгийг улсын төсөвт татан төвлөрүүлэлгүйгээр дараагийн төсвийн жилд шилжүүлэн зарцуулахаар заасантай холбоотой мөнгөн хөрөнгийн данс 96,797.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ. Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшил 50,175.0 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 8,190.0 мянган төгрөгөөр зарцуулагдаагүй үлдсэн байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 32,473.3 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,025,244.5 мянган төгрөг болж 110,652.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд шилжүүлсэн, акталсан үндсэн хөрөнгө байхгүй байна.

БШУС-ын 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдрийн А/230 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар хуваарилсан 34,454.8 мянган төгрөгийн нөхөн хангалтын санхүүжилтээс 34,198.0 мянган төгрөгөөр төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрээс гэрээний дагуу компьютер, сургалтын тоног төхөөрөмж худалдан авч хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж, тодруулсан байна.

Тайлант хугацаанд 92,641.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,826,418.3 мянган төгрөг болж 161,979.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны нийт орлого өмнөх оноос 1,228,359.7 мянган төгрөгөөр буюу 61.4 хувиар буурхад үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө өмнөх оноос 1,642,436.1 мянган төгрөгөөр буурч, санхүүжилтийн орлого 414,076.4 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Урсгал зардал өмнөх оноос 264,528.5 мянган төгрөгөөр өсчээ. Өмнөх оны үзүүлэлтээс цалин, хөлс болон нэмэгдэл урамшил 215,414.1 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 25,899.1 мянга, урсгал засвар 5,913.3 мянган төгрөгөөр тус тус өсчээ.

### **Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус сургуулийн 2023 оны төсвийг 1,212,810.1 мянган төгрөгөөр баталсныг тайлант онд 2 удаа өөрчлөлт оруулж, тодотгон оны эцэст 1,566,377.9 мянган төгрөгөөр буюу 353,567.8 мянган төгрөгөөр нэмж баталсан нь төсвийн төлөвлөлттэй холбоотой байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр 782,484.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, орон нутгийн төсвөөс 190,425.1 мянган төгрөгийг төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,566,377.9 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 96,797.1 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлээр тайлагнажээ.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /мян.төг/*

Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
<b>71802 Ерөнхий боловсрол</b>	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	3,625.0	3,625.0	0	100
	2	80312- Сургалт семинар	1,663.1	1,663.1	0	100
	3	81605- Эрүүл мэндийг дэмжих	3,326.2	3,326.2	0	100
	4	81801- Үдийн цай хөтөлбөр	62,855.6	62,855.6	0	100
	5	81806-Дотуур байрны хүүхдийн хоол	156,293.6	147,953.7	(8,339.9)	94.7

6	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	34,454.8	34,454.8	0	100
7	81823- Боловсролын багшийн сургалт	7,483.9	7,483.9	0	100
8	81834- Боловсролын стандарт сургалт	997,273.0	997,273.0	0	100
9	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	289,236.5	289,236.5	0	100
11	81848-Сурах бичгийн түрээс	3,063.8	2,772.1	(291.7)	90.5
12	80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал				
13	81827-Бичиг үсгийн боловсролын хөт	10,465.0	10,465.0		100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрсөн орлого байхгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баян-Агт сумын ЕБС-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “ЦЭСБ аудит” ХХК-ийн ахлах аудитор Ш.Ганчимэг, аудиторын туслах Д.Туяа нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг захирал, аудитор Ч.Цэрэннадмид, дараагийн шатны хяналтыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Агт сумын ЕБС нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/32 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг өмнөх оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,531,489.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 15,314.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын дүнгээс 80 хувиар

тооцон 12,251.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн дагуу ажиллажээ.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус сургууль 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад хуулиар хориглосон асуудлыг санхүүжүүлээгүй байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн байршуулсан байна.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудитаар нийт 29,278.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цай хөтөлбөрийн зардлын норм хэтрүүлэн зарцуулсан 6,545.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 2 зөвлөмж, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй бараа материалыг данснаас хасахдаа тооллогын комиссын хөрөнгийн чанар үнэлгээний жагсаалт дүгнэлтгүй, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр, захирлын тушаал гараагүй байхад зөвхөн шаардах хуудсаар зардалд тусгасан зөрчил илэрснийг тус тус арилгасан байна.

ийг хэрэгжүүлсэн, хийгдээгүй болно.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар тогтоосон 1,285.9 мянган төгрөгийн 2 төлбөрийн актыг барагдуулсан, 7,284.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 3,202.2 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 1 зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллсан байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,285.9	2	1,285.9	100
Албан шаардлага	1	7,284.0	1	7,284.0	100

Зөвлөмж	1	3,202.2	1	3,202.2	100
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>11,772.1</b>	<b>4</b>	<b>11,772.1</b>	<b>100</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 22,468.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс аудитын явцад 6,963.7 мянган төгрөгийн алдааг залруулж 9,143.3 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 1,440.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 7,921.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

Аудитын явцад шууд зардлаар бүртгэж, тайлагнасан 6,963.7 мянган төгрөгийн тусгай зориулалтын бараа материалыг үлдэгдлээр тусгуулж залруулсан.

#### 3.1 Төлбөрийн акт

1. Багш нарын гүйцэтгэгэсэн ажлыг дүгнэж, 7,739.3 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Энэ нь БШУС-ын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалын 2 дугаар хавсралт дахь “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ын 1.4-т “Багшийн ажлын үнэлгээний үр дүн нь багшид улирлын мөнгөн урамшуулал олгох үндэслэл болно”, 1.5-д “Багшийн ажлын үнэлгээг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 4.4.2-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу Боловсролын үнэлгээний байгууллага хариуцан зохион байгуулна.” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.5-т “Бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

2. Тус сургуулийн захирал Г.Пүрэвсүрэнд сумын Засаг даргын захирамжаар 1,404.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна. Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 131 дүгээр тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Боловсролын ерөнхий газрын даргыг сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын, мэргэжлийн боловсрол, техникийн боловсролын сургалтын байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагчаар томилсон, БШУС-ын 2022 оны А/500 дугаар тушаалаар ЕБС, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар, үр дүнгийн нэмэлт урамшууллыг олгосон бөгөөд энэ хүрээнд захирал, эрхлэгч нарын ажлын үр дүнгийн урамшуулал давхар шийдвэрлэгдсэн гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын “4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоосон.

#### 5.2 Албан шаардлага

1. Багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалтад тусгагдаагүй шинжилгээнд хамруулж, 1,440.0 мянган төгрөг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, БШУС, Эрүүл мэндийн сайдын 2022 оны хамтарсан А/328, 1/340 дугаар тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг хамруулах” тухай журмын 1-д заасан “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх нэмэлт үзлэг, оношилгооны жагсаалт”-ыг зөрчсөн байна.



